



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 9/287

Хэрлэн сум

Цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх  
“Бидний бахархал” арга хэмжээ зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг орон нутагт хангах зорилгоор “Бидний бахархал” арга хэмжээг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. “Бидний бахархал” арга хэмжээг зохион байгуулах хөтөлбөрийг 1 дүгээр, хуваарийг 2 дугаар, төсвийн тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Бидний бахархал” арга хэмжээг зохион байгуулахад 4,994,400 (дөрвөн сая, есөн зуун дөчин дөрвөн мянга, дөрвөн зуун) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4. Хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх “Бидний бахархал” арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгуулахыг Монгол цэргийн холбооны Хэнтий аймаг дахь салбар холбоо (Ц.Батсайхан), ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдыг бүрэн хамруулахыг Боловсрол шинжлэх ухааны газар (С.Мөнхцэцэг), мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (хурандаа Н.Хүрэлээ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2023

23101074



Аймгийн Засаг даргын 2023 оны дугаар сарын 09-ны өдрийн дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**“БИДНИЙ БАХАРХАЛ” ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Зорилго: Монгол Улсын Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”, Хан Хэнтий аймаг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд хүүхэд, залуучуудад тусгаар тогтнол, эрх эрх чөлөөний үнэ цэнийг ойлгуулах, эх орноороо болон монгол хүн болж төрснөөрөө бахархах, эх байгаль, түүх соёлоо хайрлан хамгаалах ухамсартай, улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгосон эх оронч иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

Зохион байгуулагч нь: Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штаб, Монгол цэргийн нэгдсэн холбооны салбар холбоо

Зохион байгуулагдах газар: Сумдын ерөнхий боловсролын сургуулийн урлаг заал, сумын Соёлын төвийн байр

Хугацаа: 2023 оны 5 дугаар сарын 15-25-ны хооронд Нэг суманд (2 цаг)

Ажиллагааны дараалал:

“Бидний бахархал” төслийн үйл ажиллагаанд оролцож буй зочид төлөөлөгчид, хамт олныг танилцуулах (Хөтлөгч 3 минут)

“Бидний бахархал” төслийн үйл ажиллагааг нээж, үг хэлэх

Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Н.Хүрэлээ (5 минут)

“Тусгаар тогтнол-Эрх чөлөөний үнэ цэн” төслийн видео кино үзүүлэх

Монгол цэргийн нэгдсэн холбооны салбар холбооны нарийн бичгийн дарга Ц.Батсайхан (5 минут)

Орон нутгийн төр захиргааны байгууллагыг төлөөлж үг хэлэх

Хэнтий аймгийн Засаг дарга (5 минут)

“Тусгаар тогтнол-Улс үндэстний үнэт зүйл” сэдвээр лекц унших

Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Н.Хүрэлээ (15 минут)

“Монгол цэргийн нэгдсэн холбоо” видео танилцуулга

Монгол цэргийн нэгдсэн холбооны салбар холбооны нарийн бичгийн дарга Ц.Батсайхан (10 минут)

“Монгол эх оронч үзэл, хүмүүжил хаана байна” сэдвээр лекц унших

Монгол цэргийн нэгдсэн холбооны салбар холбооны нарийн бичгийн дарга Ц.Батсайхан (10 минут)

“Монгол цэргүүд энхийн үйлсэд” видео танилцуулга

Монгол цэргийн нэгдсэн холбооны салбар холбооны нарийн бичгийн дарга Ц.Батсайхан (10 минут)

Бидний бахархал төслийн нээлтийн ажиллагаанд оролцогчдыг төлөөлж үг хэлэх / ..... дугаар сургуулийн сурагч/ (5 минут)

Урлагийн хэсэгчилсэн тоглолт

Тухайн сумын соёлын төвийн болон ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид. (20 минут)

“Бидний бахархал” төслийн үйл ажиллагааг хаах

Монгол цэргийн нэгдсэн холбооны салбар холбооны нарийн бичгийн дарга, бэлтгэл дэд хурандаа Ц.Батсайхан

Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын 09-ны өдрийн  
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

“БИДНИЙ БАХАРХАЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хянасан
1	Шатахуун	320 литр	2520	806.400	
2	Томилолт	14 хоног 3 хүн	64.000	2.688.000	
3	Мэдээлэл, сурталчилгааны самбар	10 ширхэг	150.000	1.500.000	
	Дүн			4.994.400	